

**“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ УЦК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

“Евразия капитал холдинг УЦК” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4-р сарын 04-ний өдөр 12 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөөнд өрөөнд эхлэв.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч нийт ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Энэхүү хуралд компанийн хувьцаа эзэмшигчид болох иргэн Г.Оюунболд, “Мезза Файнэншл Групп” ХХК, “Омега Инвест” ХХК, “Вистекс Глобал Инвест” ХХК нар оролцсон бөгөөд нийт 2 224 776 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 2 270 892 ширхэг энгийн хувьцааны 98% болж хурал хүчин төгөлдөр эхлэв.

Хурлын дарга Г.Халицунаа:

- Хурлыг онлайнаар нээж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:
 1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
 4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнах
 5. Бусад.

Хурлаар хэлэлцэх асуудлаа нэг бүрчлэн авч хэлэлцээд тухай бүрд нь асууж тодруулах зүйлээ асууя гэсэн саналтай байна. Та бүхэн юу гэж бодож байна?

Хуралд оролцогчид:

- Зөвшөөрч байна.

- Хурлын дарга Г.Халицунаа:

- “Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан” - гийн талаар та бүхэнд материал тараагдсан байгаа. Асуух зүйл байвал та бүхэн асуугаарай.

Компани нь үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулдаг. Цаашид гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа явуулах мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагатай байгаа тул хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай болж байгаа юм. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ олон нийтэд, хаалттай хүрээнд болон стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэхээр нэлээд ажил хийлээ. Хувьцаа нэмж гарган хувь

нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх бүх арга хэмжээг авч дууссан. Одоо зөвшөөрлөө авах л үлдлээ.

- Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигчид:

- Асуух зүйл байхгүй. Дэмжиж байна. Үйл ажиллагааны чиглэлд гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг нэмэх нь зөв.

ТУЗ-ийн Дарга Р.Отгонбат:

Компанийн дүрэмд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан энэ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанийд хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрхийг хэрэгжүүлэх саналтай байна. Нэмж хувьцаа гаргах зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг худалдаж авах үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоох, Компанийд хувьцаагаа эргүүлэн худалдахаар хүсэлт захиалгаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах үүргийг Компанийн тухай хуулийн 53-р зүйлийн 53.3-т заасны дагуу хяналтын багцын хувьцаа эзэмшигчдэд олгох саналтай байна.

Ногдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэсэн шийдвэрийг та бүхэн танилцуулж байна. Энэ компанийг өнгөрсөн хугацаанд ашиггүй ажилласантай холбоотой.

Хувьцаа эзэмшигчид:

- Асуух зүйл байхгүй. Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч "Мезза Файнэншл Групп" ХХК түүнийг төлөөлж Камоллидин Талипов:

Хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор гурван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргахтай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх нь зөв байх. Бусад гэх асуудлын хүрээнд Алдагдалтай байхад жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах хэрэгтэй байх.

Хувьцаа эзэмшигчдийн санал хүсэлтийн дараа саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

"Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна" хэмээн Тооллогын комиссын дунг тооллогын комиссын дарга Х.Мөнгөнцэцэг танилцууллаа.

Хурал: 12 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:



Г.Санжаасүрэн

Хянасан:

Хурлын дарга:

Г.Халиунаа